

ӨӨРӨӨС НЬ...

Райнэр Цитэлманн: Эдийн засгийг хөгжүүлэх цорын ганц бодитой шийдэл бол гадаадын хөрөнгө оруулалтыг татах

- ЧИНГИСЭЭР БИШ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГӨӨРӨӨ ДЭЛХИЙД ТАНИГДАНА ГЭЖ АМБИЦЛАХ ХЭРЭГТЭЙ -

» Түүрүүч нь 1 нүүрт »

-Улс орнуудыг антикапиталист, капитализмд зэрэг хандлагатай, төвийг сахисан гэж ангилсан нь сонирхолтой санагдсан. Герман, Австри, Франц зэрэг их гүрнүүд антикапиталист буюу хар жагсаалтад орсон байхад Монгол төвийг сахисан гэх ангилалд Вьетнам, Шведийн араас жагсч байна. Монголчуудын капитализмын талаарх хандлага зэрэг, хөрш Орос шигээ чөлөөт зах зээлийн замаас гарчихгүй хөгжих боломжтой гэж ойлгож болох нь ээ?

-Монголчуудын хувьд нэг онцлог ажиглагдсан. Бусад оронд олж буй орлого, боловсролын түвшин, нас, хүйснээсээ хамаарч капитализмын талаарх хандлага нь зөрүүтэй байсан бол танай улсад тийм зүйл ажиглагдсангүй.

Капитализмд хандах хандлага нь хуучин социалист дэглэмтэй байсан улсуудаас харьцангуй эерэг өнгөтэй гарлаа. Гэхдээ Польш, Чех гэх мэт улсуудаас бага зэрэг хоцролттой явж байна. Польш, Чехийн хувьд шилжилтийг маш амжилттай хийж чадсан. Орос, хуучин Югославын орнууд зэрэг улсын шилжилт хийсэн үр дүн Монголоос хоцорсон гэсэн дүгнэлт гарсан. Товчхондоо социализмаас шилжилт хийсэн 11 орон бий. Чөлөөт зах зээлийн шилжилтийг дажгүй хийсэн гэдэг үзүүлэлтээр Монгол Улс Польш, Чехийн дараа гуравдугаар байрт жагссан. Монгол улс чөлөөт зах зээлийн замаасаа гарчихгүй хөгжих бүрэн боломжтой нь эндээс харагдах байх.

-Манай зарим улстөрчид, тэр дундаа эрх баригч намын нөлөө бүхий гишүүд чөлөөт зах зээлийн шилжилтийг буруу хийсэн, Монголд зэрлэг капитализм л хөгжсөн гэсэн шүүмжлэл хэлдэг л дээ. Энэ хандлага хүчээ авбал эрсдэлтэй санагддаг. Чөлөөт зах зээлээ улам хүчирхэг болгохын тулд бидний хамгийн түрүүнд цаг алдалгүй хийх ёстой алхам юу бол?

-Антикапиталистууд капитализмын тухай ойлголтыг шашны маягтай болгочихсон байдаг л даа. Бүх муу юмны шалтгаан болгочихдог. Муу зүйл тохиолдвол бурхан харсангүй гэдэгтэй яг ижилхэн хандлага гаргадаг. Монголын хувьд зах зээлийн нийгмээ илүү сайн хөгжүүлэх ёстой. Юуны түрүүнд нүүрс, зэсийн төрийн өмчит том компаниудаа хувьчлах хэрэгтэй. Тэгж байж илүү үр дүнд хүрнэ. Би



“Хүчирхэг капитализм” номдоо төр ба чөлөөт зах зээлийн байдлын тухай харьцуулсан судалгаа хийснээ онцолж бичсэн байгаа. Наад захын жишээ гэхэд л Венесуэл байна. Далаад онд дэлхийн хамгийн том хорин эдийн засгийн нэг байсан орон. Гэтэл төрийн зохицуулалт чангарсаар байгаад эцэст нь дэлхийн хамгийн ядуу орны нэг болчихсон. Үүний эсрэг жишээ нь Хятад. Наяад оны эхэнд хүн амын ер орчим хувь нь ядуу гэсэн ангилалд багтаж явсан бол өнөөдөр хүн амынх нь нэг хүрэхгүй хувь нь ядуу байх жишээний. Ийм амжилтад хүрсэн нь ганцхан шалтгаантай. Дэн Сяо Пиний зах зээлийн эдийн засгийг нэвтрүүлэх бодлого өнөөдрийн Хятадыг бүтээсэн юм. Хятадын тухайд өөрсдийгөө ямар замаар яваагаа юугэйгээр нэрлэх нь чухал биш. Хөгжлийнх нь гол нууц зах зээлийн эдийн засгийн давуу тал, капитализмын хүчирхэг байдал гэдэг нь хэнд ч ил асуудал.

-Антикапиталист, капитализмын эсрэг хандлагатай орнууд дунд Франц, Герман, Их Британи гэх мэт эдийн засаг нь хүчирхэг том гүрнүүд харагдаж байна. Ингээд харахаар капитализм цорын ганц зөв зам биш ч юм шиг...?

-Таны хөндөж асуусан өнцгийн тухайд эдийн засгийн түрхийн асуудал л даа. Улс гүрнүүд амжилттай явсан түүхээ мартчихдаг. Яагаад, ямар шалтгаанаар амжилтад хүрснээ хэсэг зуур мартдаг гэж хэлэх гээд байна л даа. Дэлхийн хоёрдугаар дайны дараа барууны орнууд хэрхэн яаж хөгжсөн талаарх түүхийг сөхвөл чөлөөт зах зээлийн зарчмаар явсныг нь харж болно. Хувь хүнээр жишээлье.

Зуу гаруй кг жинтэй хүн эрүүл хоол, дасгал хөдөлгөөний ачаар жингээ хасчихлаа гэж төсөөлье. Жингээ хасчихаад ахиад идээд эхэллээ гэж бодъё. Хэвийн жинд хүрч, биеэ эрүүлжүүлсэн амжилтаа мартчихсан учраас идэж байгаа гэсэн үг. Улс орнуудад яг ийм процесс өрнөдөг. Дахиад хэлэхэд улс орнууд амжилтын шалтгаанаа мартчихдаг. Герман улс өнөөдөр хэцүүхэн байгаа. Бүхнийг зохицуулна гээд үзэж яваа. Хамгийн тод жишээ гэхэд л эрчим хүч, энергийн салбар байна. Цөмийн станцаас татгалзана гээд эцэстээ Америкаас хийгээ авдаг болсон. Бүхнийг зохицуулах гэсэн хандлагынхаа төлөөсөнд өнөөдөр хамгийн өндөр үнэтэй эрчим хүч хэрэглэдэг улс болчихлоо. Энэ бол зах зээлийн зарчмын эсрэг арга хэмжээний үр дагавар. Германчууд энэ алдаагаа засах байх. Зах зээлийн эдийн засгийн үзэл санаа хааяа мартагддагийн жишээ л дээ. Антикапиталистууд үнэд хяналт тавих ёстой, үнийг тогтоох шаардлагатай гэдэг. Үнэ өслөө, инфляцийг барих ёстой гэцгээдэг. Гэхдээ бодит байдал дээр тэдний энэ байр суурь зөв биш байсныг сүүлийн 200 гаруй жилийн түүх харуулдаг. Адам Смит өөрийнхөө номоор нотолчихсон. Үнэ зах зээлийнхээ зарчмаар тогтох ёгчийг тов тодорхой хэлээд өгчихсөн. Бороо их ороод байна, бороо зогсох хууль санаачилъя гэж байгаатай л адилхан зүйл. Антикапиталистуудын бас нэг онцлог нь пиар талдаа чадварлаг. Капитализмыг дэмжигчидтай харьцуулахад пиар, маркетинг талдаа үнэхээр сайн. “Би хууль батлаад бороо зогсоно, инфляцийг бууруулна” гэж

ярьцгаадаг. Гэтэл амьдрал тийм биш. Тэдний энэ хандлага бодит байдалтай огт нийцэхгүйг маш сайн ойлгох хэрэгтэй.

-Манай хоёр том гүрний дунд оршдог жижиг орон. Шатахуунаараа Оросоос хараат, Хятад хилээ хаваал өргөн хэрэглээний барааны хомсдолд орж улсаараа хэцүүдэх өндөр эрсдэлтэй. Энэ хараат байдал маань чөлөөт эдийн засгийг хүчирхэгжүүлэхэд саад бэрхшээл болох вий гэсэн эргэлзээ дагуулдаг. Та энэ тал дээр ямар бодолтой байна вэ?

-Сайхан асуулт байна. Аль ч орон ямар нэг улсаас хамааралтай байдаг. Жишээ нь манай улс Орос, Хятадаас их хамаарч байгаа. Үйлдвэрлэсэн машиныхаа ихэнхийг Хятад руу экспортолдог учраас бизнесийнхувьд Хятадаас асар өндөр хамааралтай. Хятадууд авахаа больё гэвэл манай улсын машины үйлдвэрлэл хэцүүднэ. Сингапур, Хонгконг зах зээлийг хөрсөн дээрээ буулгаж хөгжүүлж чадсан шиг Монгол Улс зах зээлийн нийгмээ илүү хөгжүүлэх боломжтой. Тэднээс суралцаж Сингапур, Хонгконг шиг хөгжих бүрэн бололцоотой. Монголчуудын тухайд бизнест талтай ханддаг, хууль дүрмийг хэрэгжүүлж чаддаг, маш бага зохицуулалт хийдэг, чөлөөт зах зээлийг дэмждэг гэх мэт олон давуу талтай. Үнэ хянадаггүй, бизнест элэгтэй гэх мэт давуу талдаа түшиглээд хөрөнгө оруулалтад ээлтэй орон гэдгээ харуулах учиртай. Татвар бага байх ёстой. Зохицуулалт бага, төрийн оролцоо хүчтэй биш, хууль дүрмийн хэрэгжилт өндөр түвшинд байчихад л болчих асуудал. Латин

Америкийн Уругвай улс гэхэд л социалист улсуудын дунд зах зээлийн нийгмийг хөгжүүлж чадаж байна. Ингээд харахаар өөрсдийгөө хэт том улсуудтай харьцуулах, нөлөөллөөс нь болгоомжлох шаардлагагүй. Жижиг зах зээл хэрхэн амжилтад хүрсэн туршлагыг хараад хөгжих учиртай. Хүн бүр бизнес хийх хүсэл эрмэлзэлтэй байх ёстой. Тэр хөрс суурийг нь бэлдэж өгөх л хамгийн чухал асуудал.

-Том хөршийнхөө хэт нөлөөллөөс гарахын тулд хийх эхний алхам гэвэл та юуг онцлох вэ?

-Герман ОХУ-аас газрын нөлөөтэй байсныг та мэднэ. Улс орнуудад том, бага алтгүй түр зуурын энэ мэт нөлөөнүүд бий. Үүнийгээ мэдээд бусдаас хамаарсан байдлаа багасгахын төлөө ажиллаж гэвэл юун түрүүнд гадаадын хөрөнгө оруулалт татах чадвар өндөр байх учиртай. Вьетнам гадаадын хөрөнгө оруулалт татах чадвараараа тэргүүлдгийг та мэднэ. Гадаадын хөрөнгө оруулалт, технологийн давуу талыг ашиглаж хөгжвөл илүү зөв шийдэл болно. “Херитэж” сангийн эдийн засгийн эрх чөлөөний байдлын индексээр Монгол Улс 100 гаруй улсаас 73-т, Азийн 39 орноос 15 дугаарт жагсч байна. Азидаа эхний хоёрт оръё, дэлхийд зээлийг дэмждэг гэх мэт олон давуу талтай. Үнэ хянадаггүй, бизнест элэгтэй гэх мэт давуу талдаа түшиглээд хөрөнгө оруулалтад ээлтэй орон гэдгээ харуулах учиртай. Татвар бага байх ёстой. Зохицуулалт бага, төрийн оролцоо хүчтэй биш, хууль дүрмийн хэрэгжилт өндөр түвшинд байчихад л болчих асуудал. Латин

-Хойд хөршийн тухайд байдал бүр хэцүүдэж байна. Монгол зах зээл,

засаглалаараа дараагийн Орос болохгүй гэх баталгаа, дархлаа өндөр улс юм байна гэсэн ойлголт тантай ярилцах зуурт төрлөө...?

-Оросуудтай харьцуулбал монголчуудад нэг том давуу тал бий. Эрх чөлөөтэй улс. Зах зээлийн эдийн засаг харьцангуй сайн хөгжиж яваа. Ингээд харахаар Оросын хэмжээнд хүртэл муудахгүй байх. Орост зах зээлийн эдийн засаг, хувийн өмч гэж ярьдаг ч удирдагчид нь хүсвэл дээрэмдье гэсэн бүхнээ дээрэмдчихдэг. Энэ бол капиталист нийгэм биш. Тийм учраас харьцуулахад хол зөрүүтэй улс орнууд. Ер нь ямар ч улс орон амбицтай байх ёстой. Эдийн засгийн эрх чөлөөний индексээ урагшуулна, бизнесийн хамгийн таатай орчмыг бүрдүүлсэн арал болно гэсэн амбицаар дэлхийд гарч ирэх ёстой. Монгол гэхээр дэлхийн улс орнууд Чингис хаанаар нь мэддэг. Өнөөдрийн Монголын хувьд эдийн засгийн эрх чөлөөгөөрөө маш таатай орон гэдгээрээ танигдана гэж амбицлах хэрэгтэй. Үүний хамгийн том загвар нь Сингапур. Сингапураас илүү Өмнөд Солонгос ч ойрхон байж мэдэх юм. Жараад онд Өмнөд Солонгос Ази, Африкийн орнуудаас ч ядуу байсан. Гэтэл өнөөдөр ямар том эдийн засаг болсныг дэлхий нийтээрээ харж байна. Жижиг орон эдийн засгаа цойлуулсан жишээ өчнөөн бий. Сингапур, Тайвань, Эстони, Люсембург бол жижигхэн улсууд. Та эдийн засгийн эрх чөлөөгөөрөө тэргүүлдэг арван орныг хараарай. Ихэнх нь танай улстай харьцуулахуйц жижиг улс байгаа.

Ц.БААСАНСҮРЭН

ТОВЧХОН

ОХУ-ын ГХЯ-ны дэд сайд Михаил Галузины “Энхийн санал”-ыг “Оросын удирдлага хууль эрх зүйн болон бодит ур чадваргүй гэдгээ л баталж байна” гэж Украины ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын зөвлөх Михаил Подольяк “твиттер” хуудсанд бичжээ. Харин Америкийн Дайны судлалын хүрээлэн (ISW) Москвагийн энэхүү мэдэгдлийг барууны орнууд Украинд туслахаа зогсоож, буулт хийж, Орост таатай нөхцлөөр энхийн хэлэлцээг эхлүүлэхэд чиглэгдсэн Кремлийн мэдээллийн ээлжит кампанит ажил гэж тайлбарлав.

Туркийн ерөнхийлөгчийн хоёр дахь шатны сонгуульд ялсан ерөнхийлөгч Режел Тайип Эрдоган инфляцитай хатуу тэмцэнэ гэж мэдэгдэв.

Усны маргаанаас үүдэн Ираны хилийн заставыг Талибан бүлэглэлийнхэн довтолж хоёр талаас хүмүүс амь үрэгдсэн гэж “Tasnim” агентлаг мэдээлжээ.

Москва хотод өглөө эрт найман дрон довтолж гурван байшин гэмтсэн гэж ОХУ-ын Батлан хамгаалах яам мэдэгдэв.

Канад улс Украинд цэргийн тусламжийн шинэ багц илгээжээ. Канадын Батлан хамгаалахын сайд Анита Анандын хэлснээр, үүнд 43 ширхэг “AIM-9” зенитийн пуужин багтсан байна.

Украины зэвсэгт хүчин Оросын армийн хамгийн олон их буу, пуужин харвагч, мин шидэгчийг энэ сард устгаад байгааг цэргийн шинжээчид Украины сөрөг довтолгоон ойртож буйн илрэл гэж дүгнэсэн байна.

Брянск мужид ОХУ-ын Батлан хамгаалах яамны “Нива” машиныг камикадзе нисгэгчгүй онгоц дэлбэлж хоёр цэргийн албан хаагч алагдсан байна.

АНУ-ын ерөнхийлөгчийн зөвлөх, нэрт дипломатч асан Хенри Киссинжер 100 насныхаа ойн өдөртэй золгожээ.

“Boeing 737 MAX”, “Airbus A320” онгоцуудтай өрсөлдөх Хятад улсын дотооддоо зохион бүтээсэн “C919” загварын анхны зорчигч тээврийн нисэх онгоц анхны нислэгээ үйлдэжээ. Энэхүү онгоцыг үйлдвэрлэхэд зарим эд ангийг нь гадаадаас импортлосон юм байна.

Италийн Венец хотын сувгийн ус хурц ногоон өнгөтэй болсон учир Хотын захиргаа уснаас дээж авч шинжлэн, шалтгааныг тодруулах мөрдөн шалгах ажиллагааг яаралтай эхлүүлсэн байна.



LIVESTOCK COMMERCIALIZATION PROJECT (LCP)

The Government of Mongolia has received a loan from the World Bank toward the cost of the Livestock Commercialization Project (LCP). The project development objective is to improve livestock health, productivity, and commercialization of targeted value chains in project locations and to provide immediate and effective response in the event of an eligible crisis or emergency. The project is structured as an IPF financed by an IDA credit in the amount of US\$30 million over five years.

The project will strengthen institutional systems and governance of veterinary services at the national level by supporting (a) analytical studies and surveys, (b) strategy formulation and policy making, (c) developing national immunization plans and monitoring rollout plans, (d) staff capacity building, (e) upgrading trainings and extension systems, and (f) information systems. In addition, it will provide intensive support to western aimags for last-mile veterinary service delivery and investments in animal disease surveillance, prevention, and control. The project will also implement value chain commercialization interventions with strategic focus on meat and dairy sectors.

The Ministry of Food, Agriculture and Light Industry is now seeking to recruit below individual for its implementing Livestock Commercialization Project (LCP). Procurement of individual consultants will be carried out in accordance with the World Bank's Procurement Regulations for IPF Borrowers, dated November 2020 and the provisions stipulated in the Financing Agreement (<http://documents.worldbank.org/curated/en/628061576551773067/Mongolia-Livestock-Commercialization-Project>).

Procurement specialist

Purpose of the assignment: The Procurement Specialist will ensure all procurement activities and documents are prepared, implemented and recorded in line with the World Bank procurement regulations. He/she will be responsible for preparing all procurement plans, bid documents, evaluating, awarding contracts and, supervising the implementation of procurement activities monitoring the track recording of the activities related with contract management of the Livestock Commercialization Project (LCP).

Please see detailed Procurement specialist ToR through <https://www.mofa.gov.mn/humanresource/abz>

Value chain assistant

Purpose of the assignment: Value chain assistant will support/assist value chain assessment on the agricultural commodities (especially milk and meat) in LCP target provinces to provide evidence-based information to programme design to Agricultural value chain specialist. In particular, market assessment should shed light on the status and viability of existing and potential milk and meat markets and determine which hold promise of employment opportunities, product expansion, market viability, value addition opportunities, quality improvement and input availability to producers.

Please see detailed Value chain assistant ToR through <http://lcp.mn/content/detail/242>

RECRUITMENT TIMETABLE:

Interested candidates are invited to submit a Cover Letter Eng/Mon, CV (Curriculum Vitae) Eng/Mon, copy of diplomas along with two reference letters, no later than **11A.M. on 5 June, 2023** for **Procurement specialist, 11A.M. on 8 June, 2023** for **Value chain assistant** to Ministry of Food, Agriculture and Light Industry at the following address: External affairs department, 6th Floor, Government building IXA, Peace avenue, Bayanzurkh District, Ulaanbaatar 13381, Mongolia or through email: procurement@lcp.mn. **Only short-listed candidates will be contacted.** Contact information: phone: 976+7010-4041